

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын эрүүл мэндийн төвийн
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/063/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Мөрөн сум

2025 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас:88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас:99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com

Аудитор Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/176
танай _____ -ны № _____ -т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Баянзүрх сумын эрүүл мэндийн төв нь тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,140,914.7 мянган төгрөгийн санхүүжилтийг авахаас гүйцэтгэлээр 1,031,400.5 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, үлдэгдэл 109,517.2 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 12,960.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Илэрсэн зөрчилд 4,016.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 8,944.5 мянган төгрөгийн 7 зөвлөмж өгсөн.

Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Баянзүрх сумын эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2024 оны гэрээний биелэлтийг 76.0 хувьтай дүгнэсэн байна.

6725701230

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

Аудитаар нийт 12,960.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Илэрсэн зөрчилд 4,016.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 8,944.5 мянган төгрөгийн 7 зөвлөмж өгсөн.

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	188,262,231.93	278,849,204.98
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,436,042.72	23,932,592.71
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	9,436,042.72	23,932,592.71
3121	Төгрөг	9,436,042.72	23,932,592.71
31211	Төрийн сангийн харилцах	9,436,042.72	23,932,592.71
33	АВЛАГА	20,551,592.00	109,517,170.29
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	20,551,592.00	109,517,170.29
35	БАРАА МАТЕРИАЛ	158,274,597.21	145,399,441.98
351	Түүхий эд материал	59,434,807.16	51,388,576.89
35130	Эм боох материал	59,434,807.16	51,388,576.89
354	Хангамжийн материал	98,839,790.05	94,010,865.09
35410	Бичиг хэргийн материал	1,096,630.00	1,206,630.00
35420	Аж ахуйн материал	58,321,191.62	63,530,656.08
35440	Түлш, шатах тослох материал	18,305,525.00	18,721,899.99
35460	Хүнсний материал	9,881,430.00	6,305,075.00
35470	Бусад хангамжийн материал	11,235,013.43	4,246,604.02
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	580,813,055.15	850,580,235.32
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	580,813,055.15	850,580,235.32
392	Биет хөрөнгө	562,883,388.36	832,925,568.45
39201	Барилга, байгууламж, орон сууц	485,609,646.60	485,609,646.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	(87,709,764.86)	(106,945,298.18)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	45,760,000.00	303,795,080.47
39204	Хуримтлагдсан элэгдэл	(35,928,333.25)	(51,003,858.43)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	230,491,477.96	290,575,737.96
39206	Хуримтлагдсан элэгдэл	(105,106,842.04)	(119,633,370.09)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,196,740.00	39,892,740.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,429,536.05)	(9,365,109.88)
393	Биет бус хөрөнгө	17,929,666.79	17,654,666.87
39301	Програм хангамж	1,375,000.00	1,375,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(469,333.21)	(744,333.13)
39303	Бусад биет бус хөрөнгө	17,024,000.00	17,024,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	769,075,287.08	1,129,429,440.30
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	769,075,287.08	1,129,429,440.30
51	Засгийн газрын хувь оролцоо	769,075,287.08	1,129,429,440.30
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	616,619,632.00	616,619,632.00
51101	Өмч: - төрийн	616,619,632.00	616,619,632.00
512	Хуримтлагдсан үр дүн	(20,891,146.93)	339,463,006.29
51210	Өмнөх үеийн үр дүн	(20,891,146.93)	(20,891,146.93)
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	360,354,153.22
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	173,346,802.01	173,346,802.01
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	769,075,287.08	1,129,429,440.30

/төгрөгөөр/

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	833,070,962.74	1,562,716,846.57
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	34,978,271.45	399,590,734.61
120	Нийтлэг татварын бус орлого	34,978,271.45	399,590,734.61
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	34,978,271.45	399,590,734.61
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	38,855,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	34,943,271.45	360,735,734.61
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	798,092,691.29	1,163,126,111.96
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	200,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	200,000.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	34,869,000.00	42,760,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	34,869,000.00	42,760,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	763,023,691.29	1,120,366,111.96
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	763,023,691.29	1,120,366,111.96
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	865,296,889.53	1,200,163,376.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	865,296,889.53	1,200,163,376.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	865,003,616.24	1,163,413,376.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	505,716,260.74	739,545,289.99
210101	Үндсэн цалин	325,475,449.72	425,569,654.83
210102	Нэмэгдэл	128,315,437.11	238,679,862.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,763,000.00	16,472,500.00
210104	Урамшуулал	47,162,373.91	58,823,272.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,747,505.97	94,044,988.58
210201	Тэтгэврийн даатгал	44,769,274.40	64,518,407.40
210202	Тэтгэмжийн даатгал	5,266,973.27	7,572,489.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,195,860.30	4,537,186.63
210204	Ажилгүйдлийн даатгал	1,046,799.00	3,478,820.36
210205	Эрүүл мэндийн даатгал	10,468,599.00	13,938,084.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,144,001.71	32,959,245.01
210301	Гэрэл, цахилгаан	6,249,001.85	8,470,523.11
210302	Түлш, халаалт	27,994,999.86	23,838,245.01
210303	Цэвэр, бохир ус	900,000.00	650,476.89
2104	Хангамж, бараа материалын зардал	56,541,497.50	62,836,282.13
210401	Бичиг хэрэг	3,117,000.00	2,923,960.00
210402	Тээвэр, шатахуун	38,846,797.50	32,415,633.11
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,540,000.00	2,640,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,253,600.00	4,488,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,973,100.00	11,805,311.00
210408	Бараа материал актальсны зардал	1,811,000.00	8,563,378.02
2105	Нормативт зардал	88,909,410.10	106,028,145.34
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	68,277,540.10	90,365,280.34
210502	Хоол, хүнс	20,631,870.00	15,662,865.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,177,000.00	25,098,500.00
210604	Урсгал засвар	21,177,000.00	25,098,500.00

2107	Томилолт, зочны зардал	1,196,000.00	4,344,000.00
210702	Дотоод албан томилолт	1,196,000.00	4,344,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,353,191.00	20,340,282.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,441,791.00	18,678,259.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	90,032.00	98,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	530,200.00	298,200.00
210807	Газрын төлбөр	55,968.00	30,423.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	83,200.00	83,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	77,218,749.22	78,216,643.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,642,000.00	5,134,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	66,576,749.22	73,082,643.41
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	293,273.29	36,750,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	36,750,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	36,750,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	293,273.29	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	293,273.29	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(32,225,926.79)	362,553,470.11
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	2,199,316.89
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	2,199,316.89
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	(2,199,316.89)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(32,225,926.79)	360,354,153.22

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	777,576,099.29	1,113,015,533.67
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,000.00	38,855,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	35,000.00	38,855,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,000.00	38,855,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	38,855,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	777,541,099.29	1,074,160,533.67
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	200,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	200,000.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	34,869,000.00	42,760,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	34,869,000.00	42,760,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	742,472,099.29	1,031,400,533.67
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	742,472,099.29	1,031,400,533.67
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	799,913,576.21	1,082,270,583.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	799,913,576.21	1,082,270,583.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	799,620,302.92	1,045,520,583.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	505,716,260.74	739,545,289.99
210101	Үндсэн цалин	325,475,449.72	425,569,654.83
210102	Нэмэгдэл	128,315,437.11	238,679,862.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,763,000.00	16,472,500.00
210104	Урамшуулал	47,162,373.91	58,823,272.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,747,505.97	94,044,988.58

210201	Тэтгэврийн даатгал	44,769,274.40	64,518,407.40
210202	Тэтгэмжийн даатгал	5,266,973.27	7,572,489.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,195,860.30	4,537,186.63
210204	Ажилгүйдлийн даатгал	1,046,799.00	3,478,820.36
210205	Эрүүл мэндийн даатгал	10,468,599.00	13,938,084.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,075,726.71	36,760,000.00
210301	Гэрэл, цахилгаан	6,249,001.85	8,470,523.11
210302	Түлш, халаалт	23,926,724.86	27,639,000.00
210303	Цэвэр, бохир ус	900,000.00	650,476.89
2104	Хангамж, бараа материалын зардал	61,584,511.50	44,998,263.11
210401	Бичиг хэрэг	3,117,000.00	2,954,160.00
210402	Тээвэр, шатахуун	41,034,311.50	29,031,253.11
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,420,000.00	2,640,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,417,000.00	2,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,596,200.00	7,872,850.00
2105	Нормативт зардал	83,473,107.00	76,831,660.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	57,657,507.00	60,235,150.00
210502	Хоол, хүнс	19,095,600.00	12,086,510.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,720,000.00	4,510,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,794,500.00	23,098,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,617,500.00	0.00
210604	Урсгал засвар	21,177,000.00	23,098,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,196,000.00	4,344,000.00
210702	Дотоод албан томилолт	1,196,000.00	4,344,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,427,191.00	20,318,882.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,515,791.00	18,662,059.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	90,032.00	98,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	530,200.00	298,200.00
210807	Газрын төлбөр	55,968.00	30,423.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	83,200.00	78,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,605,500.00	5,579,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,605,500.00	5,579,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	293,273.29	36,750,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	36,750,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	36,750,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	293,273.29	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	293,273.29	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)	(22,337,476.92)	30,744,949.99
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0.00	0.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	61,674,000.00	16,248,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	61,674,000.00	16,248,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	61,674,000.00	16,248,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	61,674,000.00	16,248,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(61,674,000.00)	(16,248,400.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(84,011,476.92)	14,496,549.99
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	93,447,519.64	9,436,042.72
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,436,042.72	23,932,592.71

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	599,595,632.00	28,676,463.22	(57,254,871.79)	571,017,223.43
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	599,595,632.00	28,676,463.22	(57,254,871.79)	571,017,223.43
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	8,859,500.64	8,859,500.64
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	616,619,632.00	173,346,802.01	(20,891,146.93)	769,075,287.08
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	616,619,632.00	173,346,802.01	(20,891,146.93)	769,075,287.08
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	616,619,632.00	173,346,802.01	(20,891,146.93)	769,075,287.08
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	360,354,153.22	360,354,153.22
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	616,619,632.00	173,346,802.01	339,463,006.29	1,129,429,440.30

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Улсын төсвийн гүйцэтгэл:

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	/ төгрөгөөр /
					Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,253,395,400.00	1,055,758,983.68	84.23	197,636,416.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,253,395,400.00	1,055,758,983.68	84.23	197,636,416.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,087,755,400.00	1,019,008,983.68	93.68	68,746,416.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	791,963,200.00	739,545,289.99	93.38	52,417,910.01
210101	Үндсэн цалин	429,690,200.00	425,569,654.83	99.04	4,120,545.17
210102	Нэмэгдэл	268,019,700.00	238,679,862.71	89.05	29,339,837.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,500,000.00	16,472,500.00	143.24	-4,972,500.00
210104	Урамшуулал	82,753,300.00	58,823,272.45	71.08	23,930,027.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,495,300.00	94,044,988.58	95.48	4,450,311.42
210201	Тэтгэврийн даатгал	66,976,700.00	64,518,407.40	96.33	2,458,292.60
210202	Тэтгэмжийн даатгал	7,879,600.00	7,572,489.68	96.10	307,110.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,939,900.00	4,537,186.63	115.16	-597,286.63
210204	Ажилгүйдлийн даатгал	3,939,900.00	3,478,820.36	88.30	461,079.64
210205	Эрүүл мэндийн даатгал	15,759,200.00	13,938,084.51	88.44	1,821,115.49
2104	Хангамж, бараа материалын зардал	45,000,000.00	44,998,263.11	100.00	1,736.89
210401	Бичиг хэрэг	3,000,000.00	2,954,160.00	98.47	45,840.00
210402	Тээвэр, шатахуун	32,000,000.00	29,031,253.11	90.72	2,968,746.89
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	2,640,000.00	132.00	-640,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000.00	2,500,000.00	100.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,500,000.00	7,872,850.00	143.14	-2,372,850.00
2105	Нормативт зардал	77,451,700.00	76,831,660.00	99.20	620,040.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	47,134,700.00	60,235,150.00	127.79	-13,100,450.00
210502	Хоол, хүнс	25,558,700.00	12,086,510.00	47.29	13,472,190.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,758,300.00	4,510,000.00	94.78	248,300.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,606,900.00	32,606,900.00	100.00	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,439,100.00	15,508,400.00	100.45	-69,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,667,800.00	00.00	0.00	3,667,800.00
210604	Урсгал засвар	13,500,000.00	17,098,500.00	126.66	-3,598,500.00
2107	Томилолт, зочны зардал	4,500,000.00	4,344,000.00	96.53	156,000.00
210702	Дотоод албан томилолт	4,500,000.00	4,344,000.00	96.53	156,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,103,000.00	20,318,882.00	74.97	6,784,118.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,632,800.00	18,662,059.00	75.76	5,970,741.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,550,000.00	1,152,000.00	74.32	398,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	102,500.00	00.00	0.00	102,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	98,200.00	98,200.00	100.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	31,100.00	00.00	0.00	31,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	457,100.00	298,200.00	65.24	158,900.00
210807	Газрын төлбөр	70,000.00	30,423.00	43.46	39,577.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	161,300.00	78,000.00	48.36	83,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10635300.00	6319000.00	59.42	4,316,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,635,300.00	6,319,000.00	59.42	4,316,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	165,640,000.00	36,750,000.00	22.19	128,890,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	165,640,000.00	36,750,000.00	22.19	128,890,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	165,640,000.00	36,750,000.00	22.19	128,890,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,253,395,400.00	1,070,255,533.67	85.39	183,139,866.33
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,076,319,400.00	1,031,400,533.67	95.83	44,918,866.33
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,076,319,400.00	1,031,400,533.67	95.83	44,918,866.33
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	177,076,000.00	38,855,000.00	21.94	138,221,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	167,640,000.00	38,855,000.00	23.18	128,785,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	9,436,000.00	00.00	0.00	9,436,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	9,436,042.72		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	23,932,592.71		

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	42,760,000.00	42,760,000.00	100.00	0.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	42,760,000.00	42,760,000.00	100.00	0.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	42,760,000.00	42,760,000.00	100.00	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,760,000.00	36,760,000.00	100.00	0.00
210301	Гэрэл, цахилгаан	6,080,000.00	8,470,523.11	139.32	-
210302	Түлш, халаалт	29,480,000.00	27,639,000.00	93.76	1,841,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	650,476.89	54.21	549,523.11
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,000,000.00	6,000,000.00	100.00	0.00
210604	Урсгал засвар	6,000,000.00	6,000,000.00	100.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	42,760,000.00	42,760,000.00	100.00	0.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	42,760,000.00	42,760,000.00	100.00	0.00

320001	Орон нутгийн төсвөөс	42,760,000.00	42,760,000.00	100.00	0.00
--------	----------------------	---------------	---------------	--------	------

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 12,960.5 мянган төгрөгийн 9 зөрчил илэрсэн. Илэрсэн зөрчилд 2 албан шаардлага, 7 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 12,960.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 13,844.7 мянган төгрөгөөс 884.2 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

- Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор тогтоосон шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20,000.0 мянган төгрөгөөс 5,579.6 мянган төгрөгөөр давсан дүнгээр худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 “Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно.” заалттай нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.
- Бараа материалын үлдэгдэлд бүтэн жилийн турш зарлагын хөдөлгөөн хийгдээгүй, өмнөх оноос шилжиж ирсэн 4,016.8 мянган төгрөгийн эмийн үлдэгдэл байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;” заалтыг хэрэгжүүлээгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул албан шаардлага хүргүүлсэн.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэнтэй холбоотой болон бусад шинээр гарсан дүрэм, журамтай нийцэхгүй болсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.” заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан дүрэм, журамтай нийцүүлэн шинэчлэн боловсруулж, мөрдөх.

2. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Орон нутгийн өмчийн байрны урсгал засварын зардал хийх зориулалттай зардлаас автомашины засвартай холбоотой 4,531.5 мянган төгрөгийн зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх

3. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант жилийн төсөвт орсон өөрчлөлтийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.1 "Худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах;" Сангийн сайдын 2023 оны А/250 тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.11 “Захиалагч цахим системд нийтэлсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллах ба энэ журмын 2.12-т заасан үндэслэлээр батлагдсан төлөвлөгөөнд орсон нэмэлт, өөрчлөлтийг холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын 10 өдөрт багтаан төлөвлөгөөнд өөрчлөлтийг тусган, батална. Хэрэв холбогдох дээд шатны байгууллага байгаа бол төлөвлөгөөний өөрчлөлтийг түүгээр батлуулахаар цахим системээр илгээж, өөрчлөлтийг баталгаажуулна.” гэж заасантай нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тайлант оны төлөвлөгөөнд өөрчлөлт орсон тухай бүрд нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлтийг оруулж батлуулах.

4. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийн асуудал

Илрүүлэлт:

2024 онд 1,155,371.1 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас нэхэмжилснээс 35,005.0 мянган төгрөг хасагдсан нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 “эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх;”, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 05 дугаар тогтоолын 3.1 “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны програм, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж,..” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны цахим системийн дотоод хяналтыг сайжруулж, хасагдалтын хэмжээг өмнөх оноос бууруулах.

5. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус эрүүл мэндийн төв www.shilendans.gov.mn цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 26, зарлагын 12 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 17 шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн нь “Шилэн дансны тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн

4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;” заалт, 6 дугаар зүйлийн 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;” заалт болон “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

6. Нягтлан бодох бүртгэлийн ажилтны урамшууллын талаар

Илрүүлэлт:

Сумын Засаг даргын 2024 оны А/115 дугаар захирамжаар эрүүл мэндийн төвийн даргад, Эрүүл мэндийн төвийн даргын тушаалаар нягтлан бодогчид зөвхөн санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” дүгнэлт авсан гэсэн ганц шалгуураар олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23.2 заалт, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар баталсан журмын 5.1 заалтад заасан шалгуур үзүүлэлттэй нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо аудитын тайланд бичигдсэн болон бусад хяналтын байгууллагаас илрүүлсэн алдаа, зөрчил, өр, авлага, мэдээ, тайлангийн хугацаа, чанар зэрэг үзүүлэлтийг харгалзаж үзэх.

7. Ахмадын сангийн талаар

Илрүүлэлт:

- Баянзүрх сумын эрүүл мэндийн төв нь ахмадын сан байгуулаагүй байгаа нь Ахмадын настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 “Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах...” гэж заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж батлуулах, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан журмыг мөрдөж ажиллах

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас автомашины сэлбэг худалдаж авч, зарцуулсан.	1	4,531.5					1	4,531.5

Нягтлан бодох бүртгийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан дүрэм, журамд нийцүүлэн шинэчлээгүй.	1	-					1	-
Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаж үзээгүй.	1	4,413.0					1	4,413.0
Дүн	3	8,944.5					3	8,944.5

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллүүдийг хугацаа хоцроож мэдээлсэн.	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Эм, эмнэлгийн хэрэгслэлийн шууд худалдан авалтын дүн ЗГ-аас тогтоосон дээд хязгаараас давсан.	1	-				1	-	
Тайлант жилийн төсөвт орсон өөрчлөлтийг тусгаж худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулаагүй.	1	-					1	-
Эмнэлгийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг цахим системд бүрэн, үнэн зөв оруулаагүйгээс нэхэмжилсэн санхүүжилтийг бүрэн авч чадаагүй.	1	-					1	-
Бараа материалын үлдэгдэлд жилийн турш хөдөлгөөн хийгдээгүй, өмнөх оноос шилжиж ирсэн эмийн үлдэгдэлтэй байна.	1	4,016.0				1	4,016.0	
Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж, батлуулаагүй байна.	1	-					1	-
Дүн	5	4,016.0				2	4,016.0	3
Нийт дүн	6	4,016.0				2	4,016.0	4

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

№ 52/АА240469/

Мөрөн сум

ХАА - 2025/063/НА - 07-Т/13

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Баянзүрх сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын үлдэгдлийг эхэлж авснаа эхэлж зарлагдах аргаар зарлагдаагүй, эмчилгээнд хэрэглэх шаардлага гараагүй, эмийн үлдэгдэлд тавих дотоод хяналт сул зэрэг шалтгаанаар тус байгууллагын бараа материалын дансны үлдэгдэлд 4,015,988 (дөрвөн сая арван таван мянга есөн зуун наян найм) төгрөгийн өмнөх оноос шилжиж ирсэн, бүтэн жилийн турш зарлагын хөдөлгөөн хийгдээгүй эм бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх," заалтыг хэрэгжүүлээгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэгээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эм, эмнэлгийн хэрэгсэл, бараа материалыг үр ашиггүй удаан хадгалахгүй байх, эмийн үлдэгдэлд тавих дотоод хяналтыг сайжруулах, бараа материалын үлдэгдлийн эхэлж авснаа эхэлж зарлагдах аргыг тууштай мөрдөж ажиллах, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор гаргаж, төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд оруулж, баталгаажуулах;

2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянзүрх сумын Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Пүрэвдорж, нягтлан бодогч Б.Мөндөрмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО

6724070469



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

№ 53/АА270469/

Мөрөн сум

ХАА - 2025/063/МӨ - СТН - ТШЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Баянзүрх сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эмийн шууд худалдан авалтын дүн нь "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор тогтоосон шууд худалдан авч болох барааны төсөвт өртгийн дээд хязгаараас 5,579,594 (таван сая таван зуун далан есөн мянга таван зуун ерэн дөрөв) төгрөгөөр хэтэрсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно." заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа Засгийн газраас тогтоосон шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг баримтлан ажиллаж, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор гаргаж, төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд оруулж, баталгаажуулах;

2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянзүрх сумын Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Пүрэвдорж, нягтлан бодогч Б.Мөндөрмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО

6724030467